



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

ХИХ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын ХИХ хурал 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 18:30 цагаас Төрийн ордны “Шадар сайдын хурлын танхим”-д 60 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Монгол Улсад КОВИД-19-ын халдварын бүртгэгдсэн тохиолдын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан үүссэн нөхцөл байдал болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар.

*Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл*

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

А. Монгол Улсад КОВИД-19-ын халдварын бүртгэгдсэн тохиолдын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймгийн орох, гарах чиглэлийн хот хоорондын зорчигч тээврийн хөдөлгөөнийг хэсэгчлэн түр зогсоох арга хэмжээ авах;

Нэг. Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт:

1.1. Шинэ төрлийн коронавирусын генийн болон тандалт, тархалт, эмнэлзүйн судалгаа хийх, цаашид эмчилгээний тактик боловсруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор АШУҮИС болон бусад эрдэм шинжилгээний байгууллагуудыг хамтран оролцуулан уг вирусийн нарийвчилсан судалгаа хийлгэх ажлыг зохион байгуулж, санхүүжилтийг БСШУСЯ-ны шинжлэх ухаан, технологийн сангаас шийдвэрлэх;

Хоёр. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав
Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбат нарт:

2.1. Сэлэнгэ аймгийн "Алтанбулаг" боомтоос олон улсын ачаа тээврийн хэрэгслийг нэгдсэн зохион байгуулалттайгаар Улаанбаатар хот руу хөдөлгөөн үйлдэх үед цагдаагийн хамгаалалтын автомашин эвдэрч, саатах тохиолдол их гарч байгаа учир тээвэрлэлтийн аюулгүй, хэвийн байдлыг хангах хүрээнд Дархан-Уул аймгийн төрийн байгууллагуудаас туулах чадвар сайтай автомашин гаргаж дэмжлэг үзүүлж ажиллах;

2.2. Олон улсын ачаа тээврийн жолооч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн тээвэрлэлтийн үед "Эрүүл мэндийн тухай" хуулинд заасны дагуу халдвар хамгаалалаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэхийг тус тус даалгав.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
НАРИЙН БИЧГИЙНДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

A handwritten signature in black ink, appearing to read "Г.Ариунбуян".

Г.АРИУНБУЯН